



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Рашаант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2024/74/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024. 02. 23 № 172
танай _____ ны № _____ т

РАШААНТ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Ж.НАРАНЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Рашаант сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2022 оны 489 дүгээр тогтоолын нэмэлт өөрчлөлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны XII/01 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын XII/01 дүгээр тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 73.2 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн

006020613

дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Рашаант сумын Засаг даргын тамгын газар нь 1 хөтөлбөр 8 зориулалт арга хэмжээний хүрээнд 912.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 859.1 сая төгрөгийг зарцуулж 52.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



Нэг. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	55,624,831.5	69,129,704.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,776,002,023.4	2,185,700,407.0
	Нийт хөрөнгийн дүн	1,831,626,854.9	2,254,830,111.7
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,831,626,854.9	2,254,830,111.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,831,626,854.9	2,254,830,111.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	900,215,622.5	1,486,418,640.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	690,628,354.4	1,059,859,217.6
	Үйл ажиллагааны үр дүн	209,587,268.1	426,559,422.4
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	2,156,165.6
	Үйл ажиллагааны нийт үр дүн	209,587,268.1	424,403,256.8
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,831,626,854.9	1,830,426,854.9
	Тайлант оны үр дүн	-	424,353,256.8
	Эцсийн үлдэгдэл	1,831,626,854.9	2,254,780,111.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	633,842,550.0	1,139,463,350.0
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	568,526,650.0	910,310,967.0
	Үйл ажиллагааны ЦМГ	65,315,900.0	229,152,383.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(67,984,300.0)	(229,152,383.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(2,668,400.0)	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	-	859,101,269.2
	Урсгал зардал	-	819,102,269.2
	Хөрөнгийн зардал	-	39,999,000.0
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	-	911,978,400.0
	Улсын төсвөөс санхүүжих	-	910,918,400.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	1,060,000.0

Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 162,629.2 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

- Бараа материал бэлтгэхдээ мөнгийг урьдчилж шилжүүлдэг ч авлага дансаар дамжуулаагүй нь УСНББОУС-1, толилуулга батламж мэдэгдэл,
- 17 нэгж талбар бүхий 14,639 м2 газрыг тайлан бүртгэлд тусгаагүй нь УСНББОУС-17, иж бүрэн байх батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 2,232,7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,172.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,060.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 2,232.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 8,126.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

1. Үр дүнгийн урамшууллыг сахилгын шийтгэлтэй нэг албан хаагчдад 872.7 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7, Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалын хавсралтын 3.11-т заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй хангахгүй байна.

2. Канастрын тэмцээний шагналд 300.0 мянган төгрөгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1-т “Нөөц хөрөнгийг дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулна”, 3.1.2-т “урьдчилан төлөвлөх боломжтой гадаад, дотоод албан томилолтын зардал, энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх хөрөнгө оруулалтын зардлыг тусгаагүй байх” гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна

3.2 Албан шаардлага

1. Тайлант онд тус ЗДТГ-т өөрийн үйл ажиллагааны орлогоос 1,060.0 мянган төгрөг орсон гэх боловч кассын бэлэн мөнгөний тайлан гаргаагүй, анхан шатны баримт дутуу нь НББ-ын тухай хуулийн 6.1, НБББББ-ын 5.1.1, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3, 7, 8-д заасныг зөрчсөн, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Цалинтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн албан хаагчдын ажлыг улирал бүр үнэлээгүй, жилийн эцэст нэг удаа үнэлж урамшуулал олгосон байна.

Өгсөн зөвлөмж: Журамд заасны дагуу төрийн албан хаагчдыг үнэлж, батлагдсан төсөвт багтаан үр дүнгийн урамшуулал олгох.

Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Рашаант сум ЗДТГ	2	162.6	1	29.3	1	133.4	2	162.6	0.0	0.0	0.0	0.0
Дүн	2	162.6	1	29.3	1	133.4	2	162.6	0.0	0.0	0.0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Рашаант сум ЗДТГ	4	2.3	2	2.3	1	1.1	1	0	0	-	0	-
Дүн	4	2.3	2	2.3	1	1.1	1	0	0	-	0	-

/сая төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Рашаант сум ЗДТГ	1	264.5			1	264.5		
Дүн	1	264.5			1	264.5		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Рашаант сум ЗДТГ	1	34.6			1	34.6		
Дүн	1	34.6			1	34.6		0
Нийт дүн	2	299.1	0	-	2	299.1	0	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			